

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗРААС 2019 ОНЫ ЕСДҮГЭЭР  
САРД ХИЙХ ҮНДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ  
2019.08.26-2019.09.25**

2019 оны 09 сарын 26-ны өдөр

Даланзадгад сум

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин	Хариуцах нэгж, албан хаагч	Биелэлт	Үнэлгээ хувиар	
						Нэгж	ХШДАО НХ
1	2	3	4	5	6	7	8
1.	Виз зөвшөөрлийн чиглэлээр	Монгол Улсад байх хөрөнгийн баталгаагүй, визийн ангиллаас өөр зорилгоор ирж буй гадаадын иргэнийг улсын хилээр нэвтрүүлэхгүй буцаах арга хэмжээ авч, буцааж буй үндэслэлийг тодорхой бүрдүүлэн, бүртгэл хөтлөж ажиллах.	Улсын хилээр нэвтрүүлэхгүй буцааж буй үндэслэл тодорхой байна.	Виз зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, хяналтын улсын байцаагч нар	Гашуунсухайт, Шивээхүрэн авто замын боомтоор “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь заалт, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.6, “Монгол Улсын виз олгох журам”-ын 3.9 дэх заалтыг тус тус үндэслэн, ярилцлага хийж БНХАУ-ын 10 иргэнийг Монгол Улсын хилээр оруулаагүй буцаасан. Тайлант хугацаанд хил орчмын нутагт зорчих нэг болон олон удаагийн үнэмлэхтэй БНХАУ-ын 139 иргэнийг бүртгэж, 142 иргэнд хасалт хийж тухайн иргэдийн шилжилт хөдөлгөөн, Монгол Улсад байх хугацаанд хяналт тавьж ажилласан.		
		Виз, урилга олголт, визийн шилжүүлэг, түр болон удаан хугацаагаар ирэгчийн бүртгэл, хасалт хийлгэх талаар гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан хүсэлтийг шуурхай хуулийн дагуу шийдвэрлэн, бүртгэл хөтлөж мэдээллийн санд баяжилт хийх.	Хуулийн дагуу хийгдсэн байна.	Хяналтын улсын ахлах байцаагч, байцаагч нар, мэргэжилтэн нар	Нийт 36 гадаадын иргэнд виз олгож, тэмдэгтийн хураамжийн 5.684.000 /таван сая зургаан зуун наян дөрвөн мянга/ төгрөгийг Өмнөговь аймгийн Татварын газрын дансанд тус тус тушаалган ажилласан болно.		
2.	Хяналт шалгалтын чиглэлээр	Батлагдсан төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг зохион байгуулах.	Удирдамж батлуулж, холбогдох хууль тогтоомжийн хяналт шалгалтын ажлыг	Хяналтын улсын ахлах байцаагч, байцаагч нар, мэргэжилтэн нар	Тайлант хугацаанд байгууллагын даргын 2019 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр баталсан 1-05/10 тоот удирдамжийн дагуу Өмнөговь, Баянхонгор, Өвөрхангай,		

1	2	3	4	5	6	7	8
	Хяналт шалгалтын чиглэлээр	Батлагдсан төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг зохион байгуулах.	зохион байгуулсан байна.	Хяналтын улсын ахлах байцаагч, байцаагч нар, мэргэжилтэн нар	<p>Дундговь аймгийн нутаг дэвсгэрт уул уурхай, барилга, малын гаралтай түүхий эд, мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж буй гадаадын иргэний бичиг баримтад хяналт шалгалт явуулах ажиллагааг зохион байгуулж байна.</p> <p>Уг хяналт шалгалтаар одоогийн байдлаар 16 аж ахуйн нэгж, байгууллагын нийт 903 (БНХАУ-ын 223, БНАСАУ-ын 60 болон бусад орны 620) гадаадын иргэний баримт бичигт хяналт шалгалт хийсэн бөгөөд хяналт шалгалтын ажиллагаа үргэлжилж байгаа болно.</p> <p>Дээрх хяналт шалгалтын хүрээнд биедээ бичиг баримтаа авч яваагүй БНХАУ-ын 6 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авч, нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн БНХАУ-ын 23 иргэнийг илрүүлэн Монгол Улсаас албадан гаргах дүгнэлтийг бичиж Хяналт шалгалтын газарт хүргүүлж, байгууллагын даргын тушаалын дагуу зөрчлийг шийдвэрлэж, албадан гаргах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.</p>		
3.	Албадан гаргах чиглэлээр	ГИЭЗБТХ зөрчсөн гадаадын иргэдийг Монгол Улсаас албадан гаргах ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэх.	Холбогдох хуулийн дагуу шийдвэрлэсэн байна.	Хяналтын улсын ахлах байцаагч, байцаагч нар	<p>Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт заасны дагуу визийн хугацааг хэтрүүлсэн БНХАУ-ын 6 иргэнийг 60.000 төгрөг, мөн хуулийн 16.2 дугаар зүйлийн 4.1 дахь заалт хуульд заасан хугацанд оршин суух зөвшөөрөл аваагүй БНХАУ-ын 1 иргэнд 108.000 төгрөг, Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 4.2 дахь хэсэгт заасан оршин суух зөвшөөрлийн хугацааг хэтрүүлсэн БНХАУ-ын 1 иргэнийг 110.000 төгрөг, Зөрчлийн</p>		

1	2	3	4	5	6	7	8
					<p>тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1.3 нутаг дэвсгэрт паспорт, паспортыг орлох баримт бичиг эсхүл оршин суух үнэмлэх биедээ авч явах журам зөрчсөн БНХАУ-ын 6 иргэнийг 600.000 төрөг, Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1.4-т заасны дагуу нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн БНХАУ-ын 23 иргэнд 2.300.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээг авч улсын төсөвт нийт 3.178.000 төгрөгийг төвлөрүүлэн, зөрчлийг арилгаж ажилласан байна.</p>		
4.	Санхүү, хангалт үйлчилгээний чиглэлээр	<p>1.Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллах.</p> <p>2.Албан хаагчдын цалин хөлс, байр ашиглахтай холбоотой зардал, хангамж, бараа материалын зардал, урсгал засвар бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал, бараа үйлчилгээний бусад зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж тусламж зэргийг хууль тогтоомжид заасны дагуу зарцуулах.</p>	Төсвийг үр дүнтэй зарцуулсан байх.	Нягтлан бодогч Нярав	<p>Энэ оны 09 дүгээр сард нийт 18 албан хаагчийн цалинд 16,179,396.47 төгрөгийг олгож, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болох байрны түрээсийн зардалд 1,806,071.52 төгрөг, хангамж, бараа материалын зардалд 259,141 төгрөг, урсгал засварын зардалд 175,050 төгрөг, томилолтын зардалд 1,092,600 төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд 130,000 төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 336,500 төгрөгийн гүйлгээ хийж Өмнөговь аймгийн Төрийн сангаар баталгаажуулан гүйлгээ хийж ажилласан байна.</p> <p>Тус газрын 2019 оны 08 дугаар сарын шилэн дансны мэдээллийг цахим сайтад байршуулж тоон мэдээг дараа сарын 02-ны дотор холбогдох нэгжид хүргүүлж ажилласан.</p>		
		Төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайлан, үнэт цаасны тооцоо, авто машин ашиглалтын болон шатах тослох материалын тооцоог үнэн зөв гаргаж, холбогдох журмын дагуу тогтоосон хугацаанд тайлагнах.	Тайлан тооцоо хугацаандаа хүргэгдсэн байх.	Нягтлан бодогч Нярав	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг дараа сарын 02-ны дотор гаргаж Өмнөговь аймгийн Төрийн сангаар баталгаажуулан төв санхүүд хүргүүлэн ажилласан. 2019 оны 08 дугаар сарын үнэт цаасны зарцуулалтын тайланг хяналтын улсын байцаагч, шатах тослох материалын зарцуулалтын тайланг		

1	2	3	4	5	6	7	8
					<p>жолооч нартай тооцоо нийлж хүлээн авч, тулгалт хийж нэгтгэн тооцоог үнэн зөв гаргаж энэ сарын 02-ны өдрийн дотор Санхүү, хангалт үйлчилгээний газарт хүргүүлж ажилласан. Байгууллагын даргын 2019 оны 09 дүгээр сарын 01-09/17 дугаар удирдамжийн дагуу тус газрын 2018, 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитын шалгалтад хамрагдан, шаардлагатай баримт бичгийг тухай бүр нь гарган өгч ажиллалаа.</p>		
		<p>Авто машины ашиглалт, хяналт, техникийн бүрэн бүтэн байдал, жолоочийн хариуцлага, ур чадварт хяналт тавьж ажиллах.</p>	<p>Автомашины ашиглалт хамгаалалтад хяналт тавин ажиллаж аюулгүй байдал хангагдсан байна.</p>	<p>Нярав</p>	<p>Газрын албан хэрэгцээнд ашиглагдаж буй автомашинуудын хяналт бүртгэлийг тухай бүр хийн, шаардлагатай сэлбэг хэрэгслийг худалдан авч тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд анхаарч ажилласан.</p>		
5.	Захиргаа, хүний нөөц, сургалтын чиглэлээр	<p>Байгууллагын даргын батлан гаргасан тушаал, дээд газраас ирүүлсэн журам, шийдвэрийг тухай бүр албан хаагч нарт танилцуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллах.</p>	<p>Тушаал шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна.</p>	<p>Захиргааны ахлах мэргэжилтэн</p>	<p>Байгууллагын даргын батлан гаргасан 5 тушаал, 1 албан даалгаврыг албан хаагчдад танилцуулан ажиллаж байна. Төв газраас ирүүлсэн хариутай албан бичгийг холбогдох албан хаагчдад шилжүүлэн хариуг тухай бүр нь хүргүүлэн ажилласан болно.</p>		
		<p>Албан хаагчдын сарын цагийн тооцоо гаргах, төрийн үйлчилгээний албан хаагчдын ур чадварын нэмэгдлийн саналыг дээд газарт хүргүүлэх.</p>	<p>Албан хаагчдын цалин хөлс хугацаандаа олгогдсон байна.</p>	<p>Захиргааны ахлах мэргэжилтэн</p>	<p>Хилийн боомтод ажиллаж буй албан хаагчдын цагийн тооцоог хүлээн авч нийт албан хаагчдын цагийн тооцоог нэгтгэн гаргаж санхүүд хүлээлгэн өгч ажилласан. Төрийн үйлчилгээний 6 албан хаагчдын ур чадварын нэмэгдэл олгох саналыг газрын даргад танилцуулан тушаалаар батлан ажилласан.</p>		
		<p>Баримт бичгийн эргэлтийг зохион байгуулах.</p>	<p>Хариутай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна.</p>	<p>Захиргааны ахлах мэргэжилтэн</p>	<p>Тус газарт ирсэн нийт 8 албан бичгийг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэж, бүртгэл-хяналтын карт хөтлөн, газрын даргад танилцуулан, холбогдох албан хаагчид шилжүүлэн шийдвэрлэлтийн явцад</p>		

1	2	3	4	5	6	7	8
5.	Захиргаа, хүний нөөц, сургалтын чиглэлээр				хяналт тавин ажиллаж байна. 2019 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт ирсэн 8 албан бичгийн хариутай 2 албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж ажилласан байна.		
		Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдол хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлүүлэх.	Өргөдөл гомдлыг хүлээн авч бүртгэх, хуульд заасан хугацаанд шийдвэрлэсэн байх.	Захиргааны ахлах мэргэжилтэн	Иргэн аж, ахуйн нэгж байгууллага, албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл гомдол хүсэлтийг хууль тогтоомжийн дагуу хугацаанд нь шийдвэрлэн ажиллаж байна. Тус газарт 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар албан хаагчаас чөлөө хүссэн 1 өргөдөл ирүүлснийг хүлээн авч шийдвэрлэн ажилласан болно. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол байхгүй болно.		
		Тус газарт ирсэн, явсан албан бичиг, газрын даргын тушаал, өргөдөл, гомдлыг цахим хэлбэрт оруулах.	Газрын ирсэн, явсан бичиг, газрын даргын тушаал, өргөдөл гомдлыг скайнердан цахим хэлбэрт оруулж, архив үүсгэсэн байна.	Захиргааны ахлах мэргэжилтэн	Тайлант хугацаанд тус газарт ирсэн нийт 8, явсан 4 албан бичгийг скайнердаж цахим хэлбэрт оруулж, байгууллагын архив албан хэрэг хөтлөлтийн програмд бүртгэн ажилласан.		
		Албан хаагчдад сургалт зохион байгуулах.	Албан хаагчид сургалтад хамрагдсан байна.	Захиргааны ахлах мэргэжилтэн	Байгууллагын “Удирдах албан тушаалтан, хяналтын улсын байцаагчдын сургалт, зөвлөгөөн”-ийг энэ оны 09 дүгээр сард Өмнөговь аймагт зохион байгуулахтай холбогдуулан дотооддоо зохион байгуулах сургалтыг 10 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.		
		ГИХГ-ын “Удирдах ажилтан, хяналтын улсын байцаагч нарын тэргүүн туршлага солилцох цугларалт” зохион байгуулах.	Бэлтгэл ажлыг бүрэн хангаж цугларалтыг зохион байгуулсан байна.	Албан хаагчид	Байгууллагын даргын 2019 оны А/310 дугаар тушаалын дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын “Удирдах албан тушаалтан, хяналтын улсын байцаагчдын сургалт, зөвлөгөөн”-ийг энэ оны 09 дүгээр сарын 11-13-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Даланзадгад хотноо зохион байгуулан ажиллалаа. Уг сургалт,		

1	2	3	4	5	6	7	8
5.	Захиргаа, хүний нөөц, сургалтын чиглэлээр				<p>зөвлөгөөнийг НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран зохион байгуулсан бөгөөд сургалтын үеэр албан хаагчид олон улсын шилжих хөдөлгөөний өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлагын талаар мэдээлэл авч, “Ажлын байранд хөдөлмөрийн мөлжлөгт өртөх, хүн худалдаалах эрсдлээс хамгаалах нь” сэдэвт сургалтад хамрагдлаа. Мөн төв газар, орон нутгийн 6 бүсийн албан хаагчид элсний волейболл, ширээний теннис, дартс гэсэн спортын төрлүүдээр авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.</p> <p>Уг сургалт, зөвлөгөөний хүрээнд Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагаас “Ажлын байранд хөдөлмөрийн мөлжлөгт өртөх, хүн худалдаалах эрсдлээс хамгаалах нь” сэдвээр сургалт, нээлттэй хэлэлцүүлгийг Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг гадаадын иргэн ажиллуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, хүний нөөцийн ажилтнуудад зохион байгуулан, харилцан санал солилцсон юм. Сургалт хэлэлцүүлэгт нийт 35 аж ахуйн нэгжийн нийт 60 гаруй ажилтнууд хамрагдсан байна.</p>		
		Шинээр баригдах барилгын зургийг Хятад хэлрүү орчуулан ӨМӨЗО-ны Хилээр орж гарах тэнхимд хүргүүлж, барилга барих бэлтгэл ажлыг ханган ажиллах.	Зургийг орчуулан холбогдох газарт хүргүүлсэн байна.	Газрын дарга Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн	Тус газарт баригдахаар төлөвлөж буй албаны болон орон сууцны барилгын зургийг хятад хэлрүү орчуулах ажлыг “Мон тай сино групп” гадаад хэлний орчуулгын компаниар хийж гүйцэтгүүлэн ӨМӨЗО-ны Хилээр орж гарах тэнхимд хүргүүлэн ажиллаж байна.		

1	2	3	4	5	6	7	8
6.	Мэдээллийн технологийн чиглэлээр	Сүлжээний тасралтгүй үйл ажиллагааг хангаж ажиллах.	Сүлжээний тасралтгүй үйл ажиллагаа хангагдсан байна.	Сүлжээний инженер	Газрын хэмжээнд сүлжээний хэвийн байдлыг ханган ажиллаж байна. Бүсийн хэмжээнд гарсан 3 эвдрэл, гэмтлийг тухай бүр нь засч сайжруулан ажилласан.		

ХЯНАСАН:  
ГАЗРЫН ДАРГА

Л.ДАМДИНСҮРЭН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:  
ЗАХИРГААНЫ АХЛАХ  
МЭРГЭЖИЛТЭН

Ш.ДЭМБЭРЭЛДУЛАМ